



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025. 05. 23 № 21

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Б.ЧОЙЖИЛСҮРЭН ТАНАА

Г Эрчим хүчний тарифын зохицуулалтын талаар

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Эрчим хүчний талаар баримталж буй бодлогуудад дотоодын үйлдвэрлэл, эрчим хүчний бие даасан байдлыг хангах, эрчим хүчний үнэ, тарифыг бодит өртөгт тулгуурлан тогтоох, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарчмыг баримтлан ажиллахаар тусгасан. Гэвч орон нутагт үйл ажиллагаа явуулж буй томоохон эрчим хүч үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн хувьд дээрх бодлогын хэрэгжилт хангалтгүй, аж ахуй нэгж алдагдал хүлээх нөхцөл байдал бүрдээд байна. Тухайлбал,

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын харьяа Дулааны цахилгаан станц /ДЦС/ нь 2024 онд нийт 348.0 сая кВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, улсын эрчим хүчний системд 283.0 сая кВт цахилгаан нийлүүлсэн. Ингэхдээ 1 кВт цахилгааныг 214.82 төгрөгөөр үйлдвэрлээд 186.34 төгрөгөөр эрчим хүчний системд нийлүүлж байгаагаас 8.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээгээд байна. Мөн тус үйлдвэр улсын эрчим хүчний нэгдсэн системээс 1,152 сая кВт цахилгаан эрчим хүчийг 312.07 төгрөгийн үнээр худалдан авч байгаа нь өөрийн үйлдвэрлэсэн эрчим хүчний тарифтай харьцуулахад үл нийцэх, эдийн засгийн хувьд алдагдалтай байдалд хүргэж байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын харьяа Дулааны цахилгаан станцаас улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг тус үйлдвэрийн өөрийн хэрэглээнд нэгдсэн сүлжээнээс буцаан авч буй эрчим хүчний хэмжээг кВт-ыг кВт-аар суутган тооцох, ингэснээр тарифын зөрүүгээс үүссэн алдагдлыг бууруулах зохицуулалт хийх талаар Эрчим хүчний яамнаас ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа, мөн энэ талаарх хэрэгжилтийг хангах эрх зүйн болон бодлогын ямар үндэслэл шийдвэр байгаа талаарх асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Д.ҮҮРИЙНТУЯА



2025000028